



2019 оны 02 дугаар сарын 15  
№06/1059/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын  
хууль**

**Эрүүл мэндийн тухай  
хуульд нэмэлт, өөрчлөлт  
оруулах тухай**

**Монгол Улсын  
Их Хурлын  
тогтоол**

**Монгол Улсын Их Хурлын  
даргыг сонгох тухай**

**Монгол Улсын  
Ерөнхийлөгчийн  
зарлиг**

**Наймдугаар Богд  
Жавзандамба хутагтын  
мэндэлсний 150 жилийн  
ойг тэмдэглэх тухай**

## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- |     |  |  |     |
|-----|--|--|-----|
| 32. | Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай                |  | 162 |
| 33. | Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай |  | 163 |

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- |     |   |           |     |
|-----|---|-----------|-----|
| 34. | Тогтоолын төсөл буцаах тухай  | Дугаар 08 | 163 |
| 35. | М.Энхболдыг Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай   | Дугаар 09 | 164 |
| 36. | Монгол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай  | Дугаар 10 | 164 |
| 37. | Г.Занданшатарыг Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай | Дугаар 11 | 165 |
| 38. | Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг огцруулах тухай   | Дугаар 14 | 165 |
| 39. | Монгол Улсын Засгийн газрын гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх тухай   | Дугаар 15 | 166 |
| 40. | Монгол Улсын Ерөнхий консулын газар нээн ажиллуулах тухай   | Дугаар 16 | 166 |
| 41. | Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай               | Дугаар 22 | 167 |
| 42. | Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойргийн нөхөн сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай                              | Дугаар 23 | 167 |
| 43. | Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг томилох тухай   | Дугаар 25 | 168 |



<b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ</b>			
44.	Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох тухай	Дугаар 176	169
45.	Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 06	171
46.	Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 07	172
47.	Наймдугаар Богд Жавзандамба хутагтын мэндэлсний 150 жилийн ойг тэмдэглэх тухай	Дугаар 09	172
48.	Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 10	174
49.	Шүүгчийн бүрэн эрхийг сэргээж, шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 11	174
<b>МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ</b>			
50.	Ажлын үнэлгээ шинэчлэн батлах тухай	Дугаар 320	175
<b>МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ</b>			
2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр		Улаанбаатар хот	
<b>ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ</b>			
<p><b>1 дүгээр зүйл.</b> Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсгийн “төвд” гэсний дараа “болон анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай эмнэлэгт” гэж нэмсүгэй.</p>			
<p><b>2 дугаар зүйл.</b> Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:</p>			
<p>“29.2.Төрийн өмчийн эрүүл мэндийн болон бусад салбарын байгууллагад 25 ба түүнээс дээш жил, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд болон анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай эмнэлэгт 10 ба түүнээс дээш жил ажилласан эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтанд тэтгэвэрт гарахад нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг үндсэн цалингийн дунджаас нь тооцож олгох бөгөөд нэг удаагийн тэтгэмж тооцох</p>			

цалингийн дундаж хэмжээ, тэтгэмж олгох шалгуур нөхцөлийг Төрийн албаны тухай хуульд заасан журмыг баримтлан тогтооно.”

**3 дугаар зүйл.** Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8 дахь хэсгийн “салбарт” гэснийг “салбар, анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай эмнэлэг” гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

### **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2019 оны 02 дугаар  
сарын 02-ны өдөр

Улаанбаатар  
хот

#### **ЭРҮҮГИЙН ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** 2016 оны 05 дугаар сарын 13-ны өдөр баталсан Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн “2019 оны” гэснийг “2021 оны” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

### **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 01 дүгээр  
сарын 24-ний өдөр

Дугаар 08

Улаанбаатар  
хот

#### **Тогтоолын төсөл буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Б.Баттөмөр, О.Батнасан, Л.Мөнхбаатар нарын гишүүдээс 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Төрийн аудитын талаар төрөөс баримлах бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Дугаар 09

Улаанбаатар  
хот

### **М.Энхболдыг Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.6 дахь заалт, 10.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын гишүүн Миеэгомбын Энхболдыг Монгол Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Энэ тогтоолыг 2019 оны 01 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА**

**Л.ЭНХ-АМГАЛАН**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 02 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 10

Улаанбаатар  
хот

### **Монгол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын даргаар Улсын Их Хурлын гишүүн Гомбожавын Занданшатарыг сонгосугай.

2. Энэ тогтоолыг 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА**

**Л.ЭНХ-АМГАЛАН**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 02 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 11

Улаанбаатар  
хот

### **Г.Занданшатарыг Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын даргаар сонгогдсон тул Гомбожавын Занданшатарыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА**

**Л.ЭНХ-АМГАЛАН**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 02 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 14

Улаанбаатар  
хот

### **Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг огцруулах тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Цэдэнбалын Цогзолмааг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын үүрэгт ажлаас огцруулсугай.

2.Энэ тогтоолыг 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 02 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 15

Улаанбаатар  
хот

### Монгол Улсын Засгийн газрын гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39<sup>1</sup> дүгээр зүйлийн 39<sup>1.2</sup> дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Янгугийн Содбаатарыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн хөгжлийн сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 02 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 16

Улаанбаатар  
хот

### Монгол Улсын Ерөнхий консулын газар нээн ажиллуулах тухай

Дипломат албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 43<sup>1</sup> дүгээр зүйлийн 43<sup>1.3</sup> дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Шанхай хотод Монгол Улсын Ерөнхий консулын газар нээн ажиллуулахаар тогтоосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 02 дугаар  
сарын 02-ны өдөр

Дугаар 22

Улаанбаатар  
хот

### **Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт явагдах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг 2019 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн товлон зарласугай.

2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт явагдах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийн санал авах өдрийг 2019 оны 06 дугаар сарын 30-ны өдөр байхаар тогтоосугай.

3.Энэ тогтоолыг 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 02 дугаар  
сарын 02-ны өдөр

Дугаар 23

Улаанбаатар  
хот

### **Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойргийн нөхөн сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай**

Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт явагдах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг 287 614 335 /хоёр зуун наян долоон сая зургаан зуун арван дөрвөн мянга гурван зуун гучин тав/ төгрөгөөр баталсугай.





2.Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-г даалгасугай.

3.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Нөхөн болон дахин сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 64 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэ тогтоолыг 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 02 дугаар  
сарын 02-ны өдөр

Дугаар 25

Улаанбаатар  
хот

### **Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1.Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайдаар доор дурдсан хүмүүсийг томилсугай:

1/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар Лувсаннамсрайн Оюун-Эрдэнийг;

2/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдаар Ёндонпэрэнлэйн Баатарбилэгийг;

3/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн хөгжлийн сайдаар Бямбасүрэнгийн Энх-Амгаланг.

2.Энэ тогтоолыг 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2018 оны 12 дугаар  
сарын 31-ний өдөр

Дугаар 176

Улаанбаатар  
хот

**Төрийн захиргааны албан тушаалын  
зэрэг дэв олгох тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, Улсын Их Хурлын 1995 оны 73 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хавсралтад дурдсан төрийн захиргааны албан хаагчдад төрийн захиргааны албан тушаалын тэргүүн түшмэлийн зэрэг дэв олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН  
БАТТУЛГА**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны  
12 дугаар сарын 31 өдрийн 176 дугаар  
зарлигийн хавсралт

**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛЫН ТЭРГҮҮН  
ТҮШМЭЛИЙН ЗЭРЭГ ДЭВ ОЛГОХ АЛБАН ХААГЧДЫН  
НЭРСИЙН ЖАГСААЛТ**

№	Овог нэр	Албан тушаал	Албан тушаалын зэрэглэл	Олгох зэрэг, дэв
1	Балдангийн Баатарзориг	Төрийн албаны зөвлөлийн гишүүн	ТӨ-VIA	Тэргүүн зэрэг
2	Цэдэвийн Цолмон	УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга	ТӨ-V	Тэргүүн зэрэг
3	Ургамалын Бямбасүрэн	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга	AA-1	Тэргүүн зэрэг



4	Должингийн Баатарсайхан	Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны дарга	АА-1	Тэргүүн зэрэг
5	Гочоосүрэнгийн Байгалмаа	Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга	АА-1	Тэргүүн зэрэг
6	Сэвжидийн Энхтүвшин	Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга	ТЗ-13	Тэргүүн зэрэг
7	Намсрайн Цагаанхүү	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга	ТЗ-13	Тэргүүн зэрэг
8	Дашдоржийн Мөрөн	Гадаадын иргэн, харьяатын газрын дарга	ТЗ-13	Тэргүүн зэрэг
9	Пүрэвдоржийн Цэрэн	УИХ-ын Тамгын газрын Захиргаа, аж ахуйн асуудал хариуцсан нарийн бичгийн дарга	АА-1	Гутгаар зэрэг
10	Галбадрахын Гантөмөр	Стандарт, хэмжил зүйн газрын дарга	ТЗ-13	Гутгаар зэрэг
11	Сандагийн Магнайсүрэн	Барилга хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга	ТЗ-14	Гутгаар зэрэг
12	Цэвэлсодномын Ганхүү	Газар, зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын дарга	ТЗ-13	Гутгаар зэрэг
13	Тогмидын Гантөмөр	Улаанбаатар хотын ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга	ТЗ-13	Гутгаар зэрэг
14	Чойжоогийн Алтангэрэл	Хүний Эрхийн Үндэсний Комиссын ажлын албаны дарга	АА-1	Дөтгөөр зэрэг
15	Дашдаваагийн Ганболд	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Захиргаа, хүний нөөцийн газрын дарга	АА-2	Дөтгөөр зэрэг
16	Энхбаатарын Бат-Идэр	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга	АА-2	Дөтгөөр зэрэг
17	Жигжидсүрэнгийн Бямбасүрэн	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Санхүү, хөрөнгө оруулалт, үйлчилгээний хэлтсийн дарга	АА-2	Дөтгөөр зэрэг
18	Хишигдаваагийн Жанцан	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Төрийн ёслолын хэлтсийн дарга	АА-2	Дөтгөөр зэрэг
19	Ядамсүрэнгийн Баттогтох	УИХ-ын Тамгын газрын Албаны дарга бөгөөд дотоод аудитор	АА-2	Дөтгөөр зэрэг



20	Бэрэнбаралын Эрдэнэбилэгт	УИХ-ын Тамгын газрын МХШҮХ-ийн дарга	АА-2	Дөтгөөр зэрэг
21	Бямбажавын Ариунаа	Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт зохицуулалтын газрын дарга	АА-3	Дөтгөөр зэрэг
22	Бадамын Батзориг	Санхүүгийн зохицуулах хорооны Захиргаа удирдлагын газрын дарга	АА-3	Дөтгөөр зэрэг
23	Моломжамцын Өлзийбат	Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын дарга	АА-3	Дөтгөөр зэрэг
24	Санжаагийн Наранцогт	Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	ТЗ-14	Дөтгөөр зэрэг
25	Гомбосүрэнгийн Өнөрбаяр	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга	ТЗ-14	Дөтгөөр зэрэг
26	Батжаргалын Нямдаваа	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга	ТЗ-13	Дөтгөөр зэрэг
27	Гун-Аажавын Манлайжав	Цөмийн энергийн комиссын Ажлын албаны дарга	ТЗ-13	Дөтгөөр зэрэг
28	Батболдын Асралт	Гаалийн ерөнхий газрын дарга	ТЗ-13	Дөтгөөр зэрэг
29	Гэндэндарамын Эрдэнэбат	Соёл, урлагийн газрын дарга	ТЗ-13	Дөтгөөр зэрэг
30	Бямбасүрэнгийн Лхагва	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга	ТЗ-13	Дөтгөөр зэрэг

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2019 оны 01 дүгээр  
сарын 15-ны өдөр

Дугаар 06

Улаанбаатар  
хот

### Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 18 дахь хэсэг, Шүүхийн захиргааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн Пүрэвсүрэнгийн Батсайханыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН  
БАТТУЛГА**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2019 оны 01 дүгээр  
сарын 15-ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар  
хот

### Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 18 дахь хэсэг, Шүүхийн захиргааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн Оросоогийн Зандрааг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН  
БАТТУЛГА**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2019 оны 01 дүгээр  
сарын 24-ний өдөр

Дугаар 09

Улаанбаатар  
хот

### Наймдугаар Богд Жавзандамба хутагтын мэндэлсний 150 жилийн ойг тэмдэглэх тухай

Туурга тусгаар улсаа сэргээн байгуулах монгол түмний чин хүсэл, олон арван жилийн тэмцлийн үр дүнд харь гүрний 200 гаруй жилийн ноёрхлыг эцэс болгон, түүхт төр улсынхаа тусгаар тогтнолыг дэлхий дахинаа зарлаж, үндэстний сэргэн мандлын эхийг тавьсан 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалын ололт, амжилтыг үеэс үед дурсан бахархаж, үйл хэргийн зорилгыг өнө мөнхөд ухамсарлан сахиж, аливаа түвшинд үл огоорон дээдэлж, хором бүрдээ хүндэтгэн, хянаж хичээвээс зохилтой.

Үүний тулд Үндэсний эрх чөлөөний хувьсгалыг тэргүүлэн удирдсан, манлайлан оролцсон, амь биеийг үл хайрлан зүтгэсэн баатарлаг эх орончид, төр нийгэм, шашны зүтгэлтнүүд, хүнд цаг үед зориг ухаан, тэсвэр хатуужил, эв санааны хүчийг үзүүлэн нэгдэж, тууштай тэмцсэн эгэл ард, иргэдийн түүхэн гавьяаг мөнхжүүлж, хойч үеэ үндэсний бахархалт үзэл санаанд хөтлөн, тусгаар тогтнолын үнэ цэн, ач холбогдлыг ойлгуулж, хайрлан хамгаалах ухамсрыг цэгцлэн төлөвшүүлэхийг эрмэлзэх нь зүйтэй.

Үндэсний эрх чөлөөний хувьсгалыг манлайлан удирдаж, Монгол төрийн хаан сууринд зарарсан, төр шашныг хослон баригч, наймдугаар Богд Жавзандамба хутагт нь өнө эртнээс улбаатай төрт улс, Монголын тусгаар тогтнолыг сэргээн мандуулах их үйл хэрэгт онцгой гавьяа байгуулсан түүхэн хүмүүн мөн.

Наймдугаар Богд Жавзандамба хутагтын баатарлаг түүх, Монголын төлөө явуулсан үйл хэргийн түүхэн болон улс төрийн ач холбогдлыг зүй ёсоор үнэлж, бодитоор мөнхлөн алдаршуулахын чухлыг онцолж байгаа түүхч эрдэмтэд, иргэний нийгмийн байгууллагуудын саналыг дэмжиж, Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Гучин дөрөвдүгээр зүйлийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагч, наймдугаар Богд Жавзандамба хутагтын мэндэлсний 150 жилийн ойг 2019 онд орон даяар тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2. Үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагч, наймдугаар Богд Жавзандамба хутагтын мэндэлсний 150 жилийн ойг тэмдэглэх хүрээнд дараах арга хэмжээг авч, хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосугай.

а) наймдугаар Богд Жавзандамба хутагтын түүхэн гавьяаг мөнхжүүлсэн дурсгалын цогцолборыг Богд хааны ордон, музейн дэргэд /орчимд/ байгуулах;

б) наймдугаар Богд Жавзандамба хутагтын түүх, Монголын төлөө явуулсан үйл хэргийн түүхэн болон улс төрийн ач холбогдлын талаар олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах;

в) наймдугаар Богд Жавзандамба хутагтын дурсгалд зориулсан кино бүтээх;

г) наймдугаар Богд Жавзандамба хутагтын амьдрал, түүхэн замналын талаарх судалгаа, баримтуудыг нэгтгэсэн эмхэтгэл бүтээх.



3.Үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагч, наймдугаар Богд Жавзандамба хутагтын мэндэлсний 150 жилийн ойг угтаж санаачлан сэдэх, бүтээн туурвих, ахих дэвжихийн идэвх гаргаж, бүх нийтийн ариун үйлс өрнүүлэн ажиллахыг ард иргэд, албан байгууллага бүрд уриалсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН  
БАТТУЛГА**

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

### **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2019 оны 01 дүгээр  
сарын 24-ний өдөр

Дугаар 10

Улаанбаатар  
хот

#### **Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Дорнод аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Үржинбадамын Одгэрэл нас барсан тул шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН  
БАТТУЛГА**

### **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2019 оны 01 дүгээр  
сарын 25-ны өдөр

Дугаар 11

Улаанбаатар  
хот

#### **Шүүгчийн бүрэн эрхийг сэргээж, шүүгчийн албан тушаалд томилох тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 17 дугаар зүйлийн 17.3, Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:



1. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний албан тушаалаас чөлөөлөгдсөн тул Оросоогийн Зандраа, Пүрэвсүрэнгийн Батсайхан нарын шүүгчийн бүрэн эрхийг тус тус сэргээсүгэй.

2. Пүрэвсүрэнгийн Батсайханыг Орхон аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН  
БАТТУЛГА**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 10 дугаар  
сарын 24-ний өдөр

Дугаар 320

Улаанбаатар  
хот

### **Ажлын үнэлгээ шинэчлэн батлах тухай**

Газрын тухай хуулийн 24.3, 58.8-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Газар зохион байгуулалтын ажлын үнэлгээ”-г 1 дүгээр, “Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийх ажлын үнэлгээ”-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Ажлын үнэлгээ батлах тухай” Засгийн газрын 2009 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 175 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**У.ХҮРЭЛСҮХ**

**БАРИЛГА, ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН САЙД**

**Х.БАДЕЛХАН**





Засгийн газрын 2018 оны 320 дугаар  
тогтоолын 1 дүгээр хавсралт

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ҮНЭЛГЭЭ

Д/д	Ажлын нэр	Ажлын зэрэглэл ба төрөл	Төлөвлөгөөт ажил	
			Хэмжих нэгж	Бүтээлийн норм
Үнэлгээ (төрөг)				
<b>Нэг. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ</b>				
1.1. Бэлтгэл ажил				
1.1.1. Төслийг боловсруулахад шаардагдах зурган болон тоон мэдээллийг цуглуулах, боловсруулах				
А) Суурь зурган мэдээлэл цуглуулах				
1.	Тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэс бүхий байр зүйн тоон зургийг цуглуулах	-	Нэг сум	-
2.	Тухайн жилийн газрын нэгдмэл сангийн тайлан, кадастрын мэдээллийн сангийн тоон байр зүйн зургийг цуглуулах	-	Нэг сум	-
3.	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хилийн цэсийг тогтоосон шийдвэр, холбогдох баримт бичгийг цуглуулах	-	Баримт бичиг/хоног	Зурган мэдээлэл бүрийн үнийг Архивын ерөнхий газраас баталсан жишиг үнээр тогтооно.
4.	Газар ашиглалтын бүтэц, байршил бүхий газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэд ангиллын суурь зургийг тоон байдлаар цуглуулах	-	Нэг аймаг	-
5.	Хөдөө аж ахуйн газар, түүний дотор тариалан, хадлангийн газрын нэгж талбарын байршил бүхий байр зүйн тоон зургийг цуглуулах	-	Нэг сум	-
6.	Зохих масштабын нарийвчлалын шаардлага хангасан агаар, сансрын хиймэл дагуулын зургийг цуглуулж, түүнд боловсруулалт хийх	-	Нэг аймаг	-
В) Ажлын зураг бэлтгэх				
Зах зээлийн ханшаар үнийг тогтооно.				
Бүтээлийн төрөл				
7.	Бэлчээрийн болон зам, шугам сүлжээ, ой, усны сан бүхий газар болон тэдгэртэй ижил масштабаар төлөвлөлт хийгдэх засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн байр зүйн зургийг тухайн жилийн газрын нэгдмэл сангийн мэдээлэл бүхий байр зүйн зурагтай давхцуулан нэгтгэж бэлтгэх	I	дм.кв	77
		II	дм.кв	71
		III	дм.кв	61
				7298
				8755
				10212

8.	Хот, тосгон, бусад суурин газар болон түүнтэй ижил масштабаар төлөвлөлт хийх бусад ангиллын газрын байр зүйн зургийг газрын мэдээллийн сангийн зурагтай давхцуулан нэгтгэж бэлтгэх	I II III	дм.кв дм.кв дм.кв	296 355 414	7298 8755 10212
9.	Тариалан, хадлангийн газрын байр зүйн зургийг газрын мэдээллийн сангийн зурагтай давхцуулан нэгтгэж бэлтгэх	I II III	дм.кв дм.кв дм.кв	14.8 17.7 20.9	7298 8755 10212
1.1.2. Нийгэм, эдийн засгийн чиглэлээр мэдээлэл цуглуулж, боловсруулалт хийх					
A) Мэдээлэл цуглуулах					
10.	Нийгэм, эдийн засгийн чиглэлийн судалгааны ажлын тайлан, холбогдох мэдээллийг цуглуулах	-	Нэг сум Нэг аймаг	- -	30000 500000
11.	Улс, бүс нутгийн болон аймаг, нийслэлийн хөгжлийн чиг хандлага, салбарын хөгжлийг тодорхойлсон бодлогын баримт бичиг, холбогдох мэдээллийг цуглуулах	-	Нэг сум Нэг аймаг	- -	30000 500000
12.	Газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэлгэрэнгүй ангиллын тооллого, газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны тайлангийн тоон болон зурган мэдээллийг цуглуулах	-	Нэг сум Нэг аймаг	- -	30000 500000
B) Мэдээлэл боловсруулах					
13.	Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд шинжилгээ, үнэлгээ хийх	-	Хүн/өдөр	-	386725
14.	Газрын нэгдмэл сангийн ангилал, газар ашиглалтын зориулалтаас шалтгаалан нийгэм, эдийн засаг, экологид үзүүлэх нөлөөлөл, үр ашиг, нөхцөл байдалд шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт гаргах	-	Хүн/өдөр	-	386725
15.	Хүн ам зүй, нутагшилт суурьшил, шилжилт хөдөлгөөн болон хүний хөгжлийн индекс, боловсролын түвшин, ажлын байрны хангамж, өрхийн бүртгэл, мэдээлэлд шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт гаргах	-	Хүн/өдөр	-	386725
16.	Тухайн нутаг дэвсгэрийн гамшгийн эрсдэлийн судалгаа, мэдээллийг холбогдох мэдээллийн сангаас цуглуулж, үнэлгээ хийх	-	Хүн/өдөр	-	386725



17.	Газар, байгалийн нөөц ашигласны татвар, төлбөрийн ногдуулалт, төсвийн орлого төвлөрүүлсэн байдалд шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт гаргах	-	Хүн/өдөр	-	386725
18.	Нийгэм, эдийн засгийн чиглэлээр хийгдсэн судалгаа мэдээлэл, үнэлгээ, дүгнэлтэд үндэслэн нөхцөл байдлын шинжилгээ хийж, газар ашиглах эрэлт хэрэгцээний төсөөлөл, тооцоог боловсруулах	-	Хүн/өдөр	-	386725
1.1.3. Байгаль-нутаг дэвсгэрийн нөхцөл, нөөцийн судалгааны мэдээлэл цуглуулж, боловсруулалт хийх					
А) Мэдээлэл цуглуулах					
19.	Хүрээлэн буй орчны судалгаа мэдээлэл, газрын төлөв байдал, чанарын тайлан, мэдээллийн тоон болон зурган мэдээллийг цуглуулах	-	Нэг сум	-	30000
		-	Нэг аймаг	-	500000
20.	Геологи, уул уурхай, эрдэс баялаг, түгэмжлэл тархацтай ашигт малтмалын талаарх судалгааны тоон болон зурган мэдээллийг цуглуулах	-	1 хуудас баримт	-	1000
		-	1х1.5 м хэмжээтэй зураг	-	4000
21.	Инженер-геологийн нөхцөл, мужлал, бүсийн судалгааны тоон болон зурган мэдээллийг цуглуулах	-	1 хуудас баримт	-	1000
		-	1х1.5 м хэмжээтэй зураг	-	4000
22.	Газар хөдлөлт, чичирхийллийн судалгааны тоон болон зурган мэдээллийг цуглуулах	-	1 хуудас баримт	-	1000
		-	1х1.5 м хэмжээтэй зураг	-	4000
23.	Усны нөөц, усны сав газрын ашиглалт, хамгаалалт болон усны хайгуул, судалгааны мэдээллийг цуглуулах	-	5-15 хоног	-	40000-1200000
24.	Байгалийн дурсгалт болон түүх, соёлын үнэт цогцолбор, хөшөө дурсгал, археологийн болон палеонтологийн олдвор бүхий газрын судалгаа, мэдээллийг цуглуулах	-	1 хуудас баримт	-	1000
		-	1х1.5 м хэмжээтэй зураг	-	4000

25.	Газрын экологийн ангиллын бүс нутгийн судалгаа, үнэлгээний тайлан, мэдээллийг цуглуулах	-	Нэг сум	-	30000
	Шардлагатай тохиолдолд цуглуулсан тоон мэдээллийн том масштабын байр зүйн зургийг жижиг масштабт шилжүүлэх	I	Дм.кв	15	7174
26.	Шардлагатай тохиолдолд цуглуулсан тоон мэдээллийн жижиг масштабын байр зүйн зургийг хэрэгцээт масштабт шилжүүлэх	II	Дм.кв	14.8	7650
27.	Шардлагатай тохиолдолд цуглуулсан тоон мэдээллийн жижиг масштабын байр зүйн зургийг хэрэгцээт масштабт шилжүүлэх	III	Дм.кв	12.7	8294
B) Мэдээлэл боловсруулах				Хэмжилт хийж, ажлын тоо, хэмжээг тодорхойлон зургийн үнийг геодези, зураг зүйн ажлын жишиг үнээр тогтооно.	
	Энэ хавсралтын 17-26 дугаарт заасан мэдээлэл, судалгаагаар тогтоосон өгөгдлүүдийг нэгтгэж, байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөл, газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ, бүсчлэлийн зургийг боловсруулах	I	дм.кв	68	52030
28.	Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээний бүсчлэлийн зургийг төлөвлөлтийн ажлын зурагтай давхцуулан газрын эрэлт хэрэгцээний төсөөлөлтэй уялдуулан бүсчлэн зураглах, төлөвлөгөөний схемийг урьдчилсан байдлаар боловсруулж хээрийн тодруулалтын үе шатны ажлын төлөвлөгөө боловсруулах, хэлэлцүүлэгт бэлтгэх	II	дм.кв	264	10636
29.	Хот, тосгон бусад суурины газрын бүсчлэл, ашиглалтын зориулалт, инженер-геологийн нөхцөл, хөрөнгө оруулалтын байдлыг газар дээр нь тодотгон хэмжилт хийж, бүсчлэлийн хил заагт өөрчлөлт оруулах санал боловсруулах (масштаб 1:1000,1:2000)	III	дм.кв	220	12407
1.2. Хээрийн судалгааны ажил					
1.2.1. Хээрийн тодруулалт хийх					
30.	Хот, тосгон бусад суурины газрын бүсчлэл, ашиглалтын зориулалт, инженер-геологийн нөхцөл, хөрөнгө оруулалтын байдлыг газар дээр нь тодотгон хэмжилт хийж, бүсчлэлийн хил заагт өөрчлөлт оруулах санал боловсруулах (масштаб 1:1000,1:2000)	I	га	20.6	1681
		II	га	17.4	1939
		III	га	15.3	2139
		II	га	24.8	1362
		III	га	18.4	1768
31.	Бүсчлэлийн хилийн заагт орох өөрчлөлтийн эргэлтийн цэгийн хэмжилт хийх	-	цэг	15	38675
	Хөдөө аж ахуй, ой, усны сан, зам шугам сүлжээ, тусгай хэрэгцээний газрын газар ашиглалт, хамгаалалтын бүсчлэл, газрын төлөв байдал, чанар, хөрөнгө оруулалтын байдлыг газар дээр нь тодотгон хэмжилт хийж, бүсчлэлийн хил заагт өөрчлөлт оруулах санал боловсруулах	I	100 га	287500	354
		II	100 га	186000	530
		III	100 га	129200	749
32.	Хот, тосгон бусад суурины газрын бүсчлэл, ашиглалтын зориулалт, инженер-геологийн нөхцөл, хөрөнгө оруулалтын байдлыг газар дээр нь тодотгон хэмжилт хийж, бүсчлэлийн хил заагт өөрчлөлт оруулах санал боловсруулах	-	цэг	15	38675



33.	Хээрийн тодруулалтын ажлын томилолтын зардал	Сангийн сайдын баталсан жишиг үнийг мөрдөнө.		
34.	Газар ашиглалтын зориулалтын бүсийн хилийн заагт орох өөрчлөлт, төлөвлөж буй төсөл, арга хэмжээний мэдээллийг оролцогч талуудад танилцуулж, хэлэлцүүлэн тулгамдсан асуудлыг тодорхойлох	-	Хүн/өдөр	386725
1.3. Санал боловсруулах ажил				
1.3.1. Салбар хоорондын газар ашиглалтын схем боловсруулах				
	Бэлтгэл үе шатанд урьдчилан боловруулсан төлөвлөгөөний ажлын зургийг хээрийн тодруулалтын ажлын (attribute) мэдээлэлтэй нэгтгэн үнэлгээ хийж, салбар хоорондын газар ашиглалтын зориулалтын бүсчлэлийг тогтоож зураглах	-	Хүн/өдөр	386725
35.		I	100 га	88665
		II	100 га	10636
		III	100 га	12407
36.	Нийгэм, эдийн засгийн судалгаа, үнэлгээ, хөгжлийн зорилтыг үндэслэн, бүс нутаг, салбар хоорондын эдийн засгийн төрөл, уялдаа холбоо, нутаг дэвсгэр-эдийн засгийн кластерын тогтолцооны схемийг боловсруулах	-	Хүн/өдөр	386725
1.3.2. Хөдөө аж ахуйн газрын ашиглалт, хамгаалалтын төлөвлөлт				
1.3.2.1. Тариалангийн газрын ашиглалт, хамгаалалтын төлөвлөлт				
	Газар тариалангийн бүсийн газрын мэдээллүүдийн зургийг ажлын зурагтай давхцуулан нэлггэж, тохиромжтой газрын үнэлгээг тогтоож, агроэкологи, ургамлын аж ахуй, газар тариалангийн зориулалтын бүсчлэлийн зургийг боловсруулах	-	ДМ.кв	44604
37.		-	Хүн/өдөр	386725
	Тариалангийн газрын ашиглалтад тавигдах үндсэн болон тусгай шаардлага, хязгаарлалтын хэм хэмжээг үндэслэн тариалангийн газрыг элэгдэл, эвдрэлээс хамгаалах, сайжруулах экологийн төслийн схем, тооцооллыг боловсруулах	-	ДМ.кв	10636
38.		-	Хүн/өдөр	386725
	Газар тариалангийн бүсэд хэрэгжих ургамлын аж ахуйн төрөлжилт, эрчимжилт, бизнес-эдийн засгийн төслүүдийн схем, тооцооллыг боловсруулах	-	ДМ.кв	10636
39.		-	Хүн/өдөр	386725
	Газар тариалангийн бүсэд суурин аж ахуй, бизнес эрхлэх, тогтвортой амьдрах орчин бүрдүүлэх газрын байршил, хэмжээг тодорхойлсон нийгмийн төслийн схем, тооцооллыг боловсруулах	-	ДМ.кв	10636
40.		-	Хүн/өдөр	386725

1.3.2.2. Бэлчээрийн газрын ашиглалт, хамгаалалтын төлөвлөлт				
		-	д.м. кв	44604
41.	Ажлын зураг, мэдээлэлд үндэслэн бэлчээрийн газар болон бэлчээрт ашиглагдаж буй бусад ангиллын газрын тохиромжтой байдлын үнэлгээ, бүсчлэл, улирлын хуваарийн зургийг боловсруулах	-	Хүн/өдөр	386725
42.	Бэлчээрт ашиглагдаж буй нийт газрын ашиглалтад тавигдах үндсэн болон тусгай шаардлага, хязгаарлалтыг үндэслэн ашиглалтаас чөлөөлж нөхөн сэргээх, сайжруулах, өвөрмөц тогтоц, экосистемийг хамгаалалтад авах экологийн төслийн схем, тооцооллыг боловсруулах	-	д.м. кв	10636
43.	Бэлчээрийн газар, бэлчээрт ашиглагдаж буй бусад ангиллын газарт хэрэгжих бэлчээр усжуулах, таримал бэлчээр байуулах, дэд бүтцийг сайжруулах бизнес-эдийн засгийн төслийн схем, тооцооллыг боловсруулах	-	д.м. кв	10636
44.	Бэлчээрийн болон суурин мал, амьтны аж ахуй эрхлэх газрын байршил, хэмжээг тодорхойлсон нийгмийн төслийн схем, тооцооллыг боловсруулах	-	д.м. кв	10636
		-	Хүн/өдөр	386725
1.3.2.3. Хадлангийн газрын ашиглалт, хамгаалалтын төлөвлөлт				
45.	Газрын тохиромжтой байдлын зураг, хээрийн тодруулалтын үр дүн, хадлангийн газрын мэдээллүүдийг ашиглан тохиромжтой байдлын үнэлгээ, ангилах, ашиглалт, хамгаалалтын бүсчлэлийн зургийг боловсруулах	-	д.м. кв	44604
46.	Хадлангийн газрын ашиглалтад тавигдах үндсэн болон тусгай шаардлага, хязгаарлалт, хадлангийн хүрэлцээ, хадлангийн газрын ургац, ашиглалтаас чөлөөлөх, услах, бордох, хашиж хамгаалах, үндсэн сайжруулалт хийх төслийн схем, тооцооллыг боловсруулах	-	д.м. кв	10636
		-	Хүн/өдөр	386725
1.3.3. Хот, тосгон, бусад суурины газар ашиглалт, хамгаалалтын төлөвлөлт				
47.	Ажлын зураг, мэдээлэлд үндэслэн газрын инженер-геологийн нөхцөл, төлөв байдал, чанарт хийсэн үнэлгээ, дүгнэлтийн дагуу хот, тосгон, бусад суурины газрын тохиромжтой байдлын үнэлгээ, газар ашиглалтын зориулалтын бүсчлэлийн зургийг боловсруулах	-	д.м. кв	10636
		-	Хүн/өдөр	386725



48.	Хот, тостон, бусад суурины газрын ашиглалтад тавигдах үндсэн болон тусгай шаардлага, хязгаарлалтыг үндэслэн газар ашиглалтын зориулалтын бүсэд хэрэгжих газрыг шинэчлэн зохион байгуулах нийгэм, эдийн засаг, экологийн схем, тооцооллыг боловсруулах	-	дм.кв	1110	5318
49.	Ашит малталал, уул уурхайн олборлолт явуулсан газрын газар ашиглалт, нөхөн сэргээлт дүйцүүлэн хамгаалалтын төслийн схем, тооцооллыг боловсруулах	-	дм.кв	111	44604
50.	Хот, тосгон, бусад суурины газрын газар ашиглалтын бүсчлэл, хил заагт өөрчлөлт оруулах, шинэ суурьшил үүсгэх, нөөцөд газар авах асуудлыг тооцсон төслийн схем, тооцооллыг боловсруулах	-	дм.кв	1110	5318
	1.3.4. Зам, шугам сүлжээний газрын ашиглалт, хамгаалалтын төлөвлөлт	-	дм.кв	58	44604
51.	Зам, шугам сүлжээний хэрэгцээт болон тохиромжтой байдлын үнэлгээ, бүсчлэлийг тогтоож, зам, шугам сүлжээний газар ашиглалтын нэгдсэн сүлжээний зургийг боловсруулах	-	Хүн/өдөр	-	386725
52.	Авто замын сүлжээний газрын ашиглалт, төлөвлөлтөд тавигдах үндсэн болон тусгай шаардлага, хязгаарлалтыг үндэслэн авто замын сүлжээний байршил, газар ашиглалт, хамгаалалт, хөгжлийн төслийн схем, тооцооллыг боловсруулах	-	дм.кв	580	10636
53.	Төмөр замын сүлжээний газрын ашиглалт, төлөвлөлтөд тавигдах үндсэн болон тусгай шаардлага, хязгаарлалтыг үндэслэн төмөр замын сүлжээний байршил, газар ашиглалт, хамгаалалт, хөгжлийн төслийн схем, тооцооллыг боловсруулах	-	дм.кв	580	10636
54.	Нисэх буудлын аэродром орчмын аюулгүйн бүсийн газар, түүнд тавигдах үндсэн болон тусгай шаардлага, хязгаарлалтыг үндэслэн нисэх буудал, аэродромыг байршуулах газар, ашиглалт, хамгаалалт, хөгжлийн төслийн схем, тооцооллыг боловсруулах	-	Хүн/өдөр	-	386725
55.	Эрчим хүчний шугам сүлжээний газрын ашиглалт, төлөвлөлтөд тавигдах үндсэн болон тусгай шаардлага, хязгаарлалтыг үндэслэн эрчим хүчний шугам сүлжээ	-	дм.кв	580	44604
		-	Хүн/өдөр	-	386725

	байршуулах газрын байршил, ашиглалт, хамгаалалт, хөгжлийн төслийн схем, тооцооллыг боловсруулах					
	Харилцаа холбоо, мэдээллийн шугам сүлжээний газрын ашиглалт, төлөвлөлтөд тавигдах үндсэн болон тусгай шаардлага, хязгаарлалтыг үндэслэн харилцаа холбоо, мэдээллийн шугам сүлжээг байршуулах газрын байршил, ашиглалт, хамгаалалт, хөгжлийн төслийн схем, тооцооллыг боловсруулах	-	дм.кв	580		44604
56.	Дамжуулах хоолойн газрын ашиглалт, төлөвлөлтөд тавигдах үндсэн болон тусгай шаардлага, хязгаарлалтыг үндэслэн дамжуулах хоолойн газар ашиглалт, хамгаалалт, хөгжлийн төслийн схем, тооцооллыг боловсруулах	-	дм.кв	580		44604
57.	Ойноос хамгаалалт, хөгжлийн төслийн схем, тооцооллыг боловсруулах	-	Хүн/өдөр	-		386725
	1.3.5. Ойн сан бүхий газрын газар ашиглалт, хамгаалалтын төлөвлөлт					
	Ойн судалгаа, ой зохион байгуулалтын мэдээллүүдийг давхцуулан нэгтгэж, ойн хэв шинж, ландшафт, ойн экологи-эдийн засгийн бүсчлэлийг тогтоож, ойн сангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ, бүсчлэлийн зургийг боловсруулах	-	дм.кв	58		44604
58.	Ойн сангийн газар ашиглалт, хамгаалалтад тавигдах үндсэн болон тусгай шаардлага, хязгаарлалтыг үндэслэн ойн сангийн газарт хэрэгжих экологийн төслийн схем, тооцооллыг боловсруулах	-	Хүн/өдөр	-		386725
59.	Ойн сангийн газар ашиглалт, хамгаалалтад тавигдах үндсэн болон тусгай шаардлага, хязгаарлалтыг үндэслэн ойн сангийн газарт хэрэгжих экологийн төслийн схем, тооцооллыг боловсруулах	-	дм.кв	580		10636
60.	Ойн сангийн газарт хэрэгжих ой, ан агнуурын аж ахуй хөгжүүлэх, ойн дагалт баялаг ашиглах бизнес-эдийн засгийн төслүүдийн схем, тооцооллыг боловсруулах	-	Хүн/өдөр	-		386725
61.	Ойн сангийн газарт иргэд суурьших, бизнес эрхлэх, тогтвортой амьдрах газрын байршил, хэмжээг тодорхойлсон нийгмийн төслийн схем, тооцооллыг боловсруулах	-	дм.кв	580		10636
	1.3.6. Усны сан бүхий газрын газар ашиглалт, хамгаалалтын төлөвлөлт					
	Усны сангийн газрын ашиглалт, хамгаалалтад тавигдах үндсэн болон тусгай шаардлага, хязгаарлалтыг үндэслэн усны нөөцийн ашиглалт, хамгаалалтын бүсэд хэрэгжих экологийн төслийн схем, тооцооллыг боловсруулах	-	дм.кв	58		44604
62.	Усны сангийн газар ашиглалт, хамгаалалтад тавигдах үндсэн болон тусгай шаардлага, хязгаарлалтыг үндэслэн усны нөөцийн ашиглалт, хамгаалалтын бүсэд хэрэгжих экологийн төслийн схем, тооцооллыг боловсруулах	-	Хүн-өдөр	-		386725





63.	Усны сангийн газарт эрхлэх загасны аж ахуй, загасчлал, усан аялал, тээвэр хөгжүүлэх, усан цахилгаан станц, усны барилга байгууламж барих газрын бизнес-эдийн засгийн төслийн схем, тооцооллыг боловсруулах	-	Д.М.КВ	58	44604
	1.3.7. Улсын тусгай хэрэгцээний газрын ашиглалт, хамгаалалтын төлөвлөлт	-	Д.М.КВ	58	10636
64.	Газрын экологийн ангилалд үндэслэн хамгаалалтад шинээр авах, одоо байгаа тусгай хамгаалалттай газрын хил заагийг шинэчлэх, өөрчлөх, дотоод бүсчлэлийн хил заагийг тогтоох экологийн төслийн схем, тооцооллыг боловсруулах	-	Хүн/өдөр	-	386725
	Тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөгдсөн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх газрын хил заагийг тогтоох, ашиглалт, хамгаалалтад тавигдах үндсэн болон тусгай шаардлага, хязгаарлалтыг үндэслэн аялал жуулчлал болон тусгай хамгаалалттай газар нутгийг хөгжүүлэх төслийн схем боловсруулах	-	Д.М.КВ	58	10636
65.	Хилийн зурвас газарт зөвшөөрөгдсөн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх газрын хил заагийг тогтоох, ашиглалт, хамгаалалтад тавигдах үндсэн болон тусгай шаардлага, хязгаарлалтыг үндэслэн хилийн зурвас газрын газар ашиглалтын төслийн схем, тооцооллыг боловсруулах	-	Хүн/өдөр	-	386725
66.	Чөлөөт бүсийн газрын ашиглалт, хамгаалалтад тавигдах үндсэн болон тусгай шаардлага, хязгаарлалтыг үндэслэн газар ашиглалтын зориулалт, үүргийн бүс, дэд бүсчлэл тогтоож газар ашиглалтын төслийн схем, тооцооллыг боловсруулах.	-	Д.М.КВ	58	10636
